



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

᠒᠐᠒᠖ оны ᠐ᠪ сарын ᠒᠐ өдөр

Дугаар ᠕/᠖᠑

Улаанбаатар хот

Орон нутгийн төсвөөс санхүүждэг
байгууллагуудын төрийн үйлчилгээний
албан тушаалын цалингийн хэмжээг
шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн “Төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн талаар авах арга хэмжээний тухай” 224 дүгээр тогтоолын 3 дахь заалт, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны 26/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн төсвөөс санхүүждэг төрийн үйлчилгээний байгууллагын удирдах албан тушаалтны цалингийн хэмжээг хавсралтаар баталсугай.

2.Дүүргийн орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагуудын төрийн үйлчилгээний албан хаагчдын албан тушаалын цалингийн хэмжээг 2026 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн батлагдсан төсөвтөө багтаан 10 хувиар нэмэгдүүлэн тогтоохыг дүүргийн төсвийн шууд захирагч нарт зөвшөөрсүгэй.

3.Төрийн үйлчилгээний албан хаагчдын албан тушаалын чиг үүргийн давхардлыг арилгах, зайлшгүй шаардлагатайгаас бусад сул орон тоонд албан хаагч нөхөж авахгүй байх, үр ашиггүй зардлыг багасгах, ажлын гүйцэтгэл үр дүн, бүтээмжийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг цахимжуулах зэрэг арга хэмжээ авч ажиллахыг төсвийн шууд захирагч нарт үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Х.Цогцэцэг), Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (Б.Отгонжаргал)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД